



**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2015 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 11/75

Улаанбаатар хот

Төлбөрт үйлчилгээний тариф батлах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 5.1, 11.1, Зам, тээврийн сайдын 2013 оны 232 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах” журмын 4.2, Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журмын 3.5, тус үндэсний төвийн дүрмийн 6.9.9, 6.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тээврийн хэрэгсэлд хууль хяналтын байгууллагын шийдвэрээр ослын дүгнэлт гаргасан, хийцийн өөрчлөлт хийж хөдөлгүүр сольсон, арал болон бүхээг сольсон, нэмэлт төхөөрөмж суурилуулсан техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт гаргахад бүрдүүлэх бичиг, баримтын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, дээрхи үйлчилгээ болон тээврийн хэрэгслийн эзэмшигчийн хүсэлтийн дагуу сүүлийн үеийн дэвшилтэт технологи, компьютер ашиглан хөдөлгүүрийн гэмтлийг оношлох, гэрлийн тусгал болон тэнхлэг тохируулах үйлчилгээний төлбөрийн тарифыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Техникийн байдлын дүгнэлтийг мэргэшсэн инженер гаргаж, зөвлөх инженерээр баталгаажуулж байхыг техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн дарга нарт даалгасугай.

3.Батлагдсан үнэ дээр нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувийг нэмэгдүүлэн тооцоолж төлбөрт үйлчилгээний орлогыг тайлан, бүртгэлд тусгахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ц.Бат-Өлзий/-т зөвшөөрсүгэй.

4.Энэ тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн таниулан сурталчилж, хэрэгжүүлэн ажиллахыг Техникийн хяналтын газар /Б.Энхцэцэг/-т үүрэг болгосугай.


5.Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Техникийн хяналт, бүртгэл хариуцсан дэд захирал /Т.Баясгалан/-д даалгасугай.

6.Энэ тушаал гарсантай холбогдуулан Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын албаны захирлын 2010 оны 35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ  Н.ПУНЦАГ



Автотээврийн үндэсний төв ТӨУГазрын
захирлын 2015 оны 11-р сарын 12 ны
өдрийн тушаалын нэгдүгээр хавсралт



Дүгнэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

Тээврийн хэрэгсэлд хийцийн өөрчлөлт хийж хөдөлгүүр сольсон, арал сольсон, нэмэлт төхөөрөмж суурилуулсан, хууль хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу техникийн байдалд техникийн дүгнэлт гаргахад дараах бичиг баримтыг үндэслэнэ. Үүнд:

1.Хийцийн өөрчлөлт хийж хөдөлгүүр сольсон тээврийн хэрэгсэлд техникийн дүгнэлт гаргахад:

- 1.1 Техникийн дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг тус үндэсний төвд гаргах
- 1.2 Хөдөлгүүр худалдан авсан баримт
- 1.3 Хөдөлгүүр сольж тавьсан засварын газрын тодорхойлолт
- 1.4 Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- 1.5 Хөдөлгүүр солих болсон шалтгаан.

2.Арал сольсон тээврийн хэрэгсэлд техникийн дүгнэлт гаргахад:

- 2.1 Техникийн дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг тус үндэсний төвд гаргах
- 2.2 Сольж тавьсан арлын гаалийн мэдүүлэг, эсхүл улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт
- 2.3 Арал худалдан авсан баримт
- 2.4 Арал сольж тавьсан засварын газрын тодорхойлолт
- 2.5 Хуучин арлын дугаар, пайзыг биетээр нь авчрах
- 2.6 Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- 2.7 Солих болсон шалтгаан. (Цагдаагийн байгууллага, Үнэлгээний байгууллага, Онцгой байдлын газрын тодорхойлолт гэх мэт.)


3.Нэмэлт төхөөрөмж суурилуулсан тээврийн хэрэгсэлд техникийн дүгнэлт гаргахад:

- 3.1 Техникийн дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг тус үндэсний төвд гаргах
- 3.2 Нэмэлт төхөөрөмжийн талаархи Мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт
- 3.3 Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- 3.4 Нэмэлт төхөөрөмж суурилуулах болсон шалтгаан

4. Хууль хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу техникийн байдалд ослын дүгнэлт гаргахад:

- 4.1 “Автомашинд ослын шинжилгээ хийлгэх тухай” тогтоол
- 4.2 Тухайн тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар

Автотээврийн үндэсний төв ТӨҮГазрын
захирлын 2015 оны 17 сарын 2 ны
өдрийн тушаалын хоёрдугаар хавсралт



Төлбөрт үйлчилгээний тариф

№	Үйлчилгээний төрөл	Тариф /төгрөгөөр/	
1	Тээврийн хэрэгсэлд хийцийн өөрчлөлт хийж хөдөлгүүр сольсон, арал сольсон, нэмэлт төхөөрөмж суурилуулсан тээврийн хэрэгсэлд техникийн дүгнэлт гаргах	50000	
2	Хууль хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу техникийн байдалд ослын дүгнэлт гаргах	80000	
3	Тэнхлэг тохируулах	Бүх жин 3.5 тонноос дээш тээврийн хэрэгсэл	20000
4		Бүх жин 3.5 тонноос доош тээврийн хэрэгсэл	15000
5	Гэрлийн тусгал тохируулах	5000	
6	Хөдөлгүүрийн гэмтлийг компьютерээр оношлох	15000	

оОо